



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/363

Чойбалсан

Г

Комисс байгуулах тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 4.2.2 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын нутаг дэвсгэрт "Алс зурай" ХХК-ийн гүйцэтгэсэн "Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах (Нэг цэгийн үйлчилгээний төв)-ийн үйл ажиллагааны зардалд дэмжлэг үзүүлэх" ажлын барилга угсралтын ажлыг хүлээн авах, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	А.Түмэнжаргал	-Аймгийн Ерөнхий архитектор
Гишүүд:	Т.Баярмаа	-Аймгийн Засаг даргын тамгын газрын Архивын тасгийн Сан хөмрөгч
	М.Гансүмбэр	-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
	Б.Одсүрэн	-Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Ч.Сайхангэрэл	-Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Ч.Лхагвасүрэн	-Зураг төслийн байгууллагын төлөөлөл, "ДОЗТ" БГБХН-ийн захирал
Нарийн бичгийн дарга:	Т.Төрболд	-Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл, "Алс зурай" ХХК-ийн захирал

2.Комиссын үйл ажиллагааг Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах дүрэм"-ийн дагуу удирдан зохион байгуулж, ажлын дүгнэлтийг аймгийн Засаг даргад урьдчилан танилцуулсны дараа албан ёсоор баталгаажуулахыг Комиссын дарга (А.Түмэнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ЁЛ